



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ КУВЕЙТЫН БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Х.ЕРХУЛАН ТАНАА

2025.03.25 № 07/1175
танай _____-ны № _____-т

Дүгнэлт өгөхөөс татгалзсан

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейтийн байгаль хамгаалах төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тодруулгуудад аудит хийлээ.

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тодруулгуудад дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зүйлс нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгэж хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, хөрөнгийн жилийн эцсийн тооллого, санхүүгийн тайланд туссан авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн акт зэрэг аудитын горим сорил хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй зэрэг нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө, бараа материалын тоо хэмжээний талаар бүрэн итгэл үнэмшил бий болгох, өөрчлөлт оруулах элементтэй холбоотойгоор ямар нэг залруулга хийх шаардлагатай эсэхийг тогтоох боломжгүй болсон.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ